



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/01



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	19-22
Дөрөв. Гэмт хэрэг.....	23-24
Тав. Мөнгө,зээл	25
Зургаа. Төсөв, санхүү	26-27
Долоо. Үнэ.....	28-31
Найм. Хөдөө аж ахуй	32-33
Ес. Аж үйлдвэр.....	34-38
Арав. Барилга	39-41
Арван нэг. Байгаль орчин	42

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 01 дүгээр сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 20120 оны 01 сард 148 эх амаржиж, 149 хүүхэд шинээр мэндэлж, 41 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 40(37.0%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 39(35.5%)-өөр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 6(14.6%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 114 болж 2019 оны мөн үеийнхээс 45(65.2%)-аар өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 2.1, нас баралт 0.5 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 01 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 2 байна.



1.2 Эрүүл мэнд

2020 оны 01 сарын байдлаар 44.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар, 2.1 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар тус тус өсч, 1.0 мянган хүн




урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

2020 оны 01 сард 203 эх жирэмсний хяналтанд орсны 93.1 хувь буюу 189 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 2.9 мянган удаа гарсны 0.4 мянга буюу 13.8 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар ослын улмаас 238 хүн бэртэж, 5 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 131(22.4%)-ээр өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 01 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд бусад төрлийн өвчин 31.4 хувь, хавдар 22.9 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 20.0 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 14.3 хувь, хоол шингээх эрхтний өвчин 11.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 121 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 36-аар буюу 42.4 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд заг хүйтэн 92.3 хувь, бусад төрлийн өвчин 3 дахин өссөн нь тус тус голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 01 сарын эцэст 243 болсны 241(99.2%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 2 (0.8%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 1434(85.5%) хүнээр, өмнөх сараас 636(72.4%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 129(53.1%) нь бүрэн дунд, 50(20.6%) нь дээд, 23(9.5%) нь техник болон мэргэжлийн, 18(7.4%) нь бүрэн бус дунд, 15(6.2%) нь тусгай дунд, 4(1.6%) нь бага, 3(1.2%) нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 01 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 01 сарын байдлаар шинэ ажлын байр, ажилд зуучлагдан орсон болон ажлын байрны захиалга бүртгэгдээгүй байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 01 сарын байдлаар 2814.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 294.2 (11.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 01 сард өмнөх оны мөн үеэс 294.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 188.5 (11.8%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 469.1 (11.8%), ҮОМШӨ-ний даатгал 28.6 (11.1%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 20.3 (11.3%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 7.4 (10.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 01 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 4327.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 368.3(9.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 3307.6 (76.4%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 389.2 (9.0%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 364.3 (8.4%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 99.7 (2.3%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 167.0 (3.9%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 01 сард нийгмийн халамжийн сангаас 7470 иргэнд 523.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 6987(48.3%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 722.1(58.0%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 01 сард 1232 хүн хамрагдсан нь өмнөх оноос 17(18.4%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 21.5(9.0%) сая төгрөгөөр тус тус буурчээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 817 иргэнд 70.0 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 225 иргэнд 45.3 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 2892 иргэнийг хамруулж, 71.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 2304 иргэн хамрагдаж, 118.6 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 55 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 12 хүн гэмтэж, 3 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 10(15.4%)-аар, гэмтсэн хүний тоо 5(29.4%) -аар, нас барсан хүний тоо 8(72.7%)-аар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1(5.3%)-ээр, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 9(4 дахин)-өөр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2(40.0%)-оор өсч, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3(75.0%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 10(50.0%)-аар, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 8(72.7%)-аар тус тус буурчээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 21.8 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 18.2 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 12.7 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 1.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 9.1 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 4 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8(66.7%)-аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Мандах, Улаанбадрах сумдад гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 125.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.2 (28.2%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 34.5 (27.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 11(20.0%) нь гэр орон сууцандаа, 4(7.3%) нь согтуугаар, 5(9.1%) нь гудамж олон нийтийн газарт, 7(12.7%) бүлэглэн, 3(5.5%) хувийг эмэгтэй хүн оролцон, 12 (21.8%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 95 хүн саатуулагдаж, 9 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 01 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.0 мянга болж өмнөх оноос 1.6(4.6%) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламж эзэмшигчийн тоо 72.8 мянга болж өмнөх оны мөн үеээс 1.0 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 118.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1631.9 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1706.9 мянган төгрөгийн

хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.5 (14.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 01 дүгээр сарын эцэст 5.2 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.5 (9.9%) тэр бум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 2.7(2.1²) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр өсч, өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл 01 дүгээр сарын эцэст 7877.0 сая төгрөг болж өмнөх сараас 594.8(8.2%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 1051.0(15.4%) сая төгрөгөөр өсч байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.0 хувийг эзэлж өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.01 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.1 сард





2.2 Төсөв, санхүү

2020 оны 01 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 2753.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 42.5 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 76.8 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 72.9 хувийг татварын, 27.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 01 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 2104.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 1750.1 (4.1²) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 1597.0 (5.9²) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 01 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.7 хувиар, согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.3 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 0.1 хувиар, тээврийн бүлэг 0.1 хувиар, бусад бараа, үйлчилгээний бүлэг 0.1 хувиар өссөн, бусад бараа үйлчилгээний бүлэг тогтвортой байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 3.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 4.1 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 4.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 6.7 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 2.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 2.9 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 18.6 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг




26.8 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 2.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 01 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 01 дүгээр сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Том малын зүй бус хорогдол 2020 оны 01 сард аймгийн хэмжээнд 45 болж, өмнөх оны мөн үеэс 6 (15.4%) толгойгоор нэмэгдсэн байна. Нийт хорогдсон малын 64.4 хувийг ямаа, 31.1 хувийг хонь эзэлж байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Хөвсгөл суманд хамгийн их буюу 1400.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Иххэт, Өргөн, Хөвсгөл, Замын-үүд сумдад их буюу 1000.0 мянган төгрөг, Эрдэнэ суманд хамгийн бага буюу 650.0 мянган төгрөг, хязаалан гуна Иххэт, Өргөн сумдад хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Иххэт суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Хатанбулаг суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Дэлгэрэх, Эрдэнэ сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 01 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 4474.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 18553.0 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах

зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 66.5 хувиар, борлуулалт 24.2 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 01 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 66.5 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 6604.6 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 27.4 хувийг төрийн, 72.6 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 27.4 хувь, компани 70.7 хувь, өрхийн аж ахуй 1.9 хувийг тус тус эзэлж байна.


Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 8.6 мян.ккалаар, ус түгээлт 21.3 мян.м3-аар, сувагжуулалт 69.6 мян.м3-аар, савласан цэвэр ус 70.0 мян.литрээр, талх 11.2 тонноор, бялуу 0.8 тонноор, хиам 8.4 тонноор, сүүн бүтээгдэхүүн 0.3 мян.литрээр, хэрчсэн гурил 7.4 мян.тн-оор, банш бууз 0.5 тонноор, гутал 31 ширхгээр, шохой 1000 тонноор, модон эдлэл 7436.7 мянган төгрөгөөр, хайрга 3.8 мян.м3-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.



3.3 Барилга угсралт, их засвар

2019 онд нийт 170117.4 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 59.8 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15.9 хувийг улсын төсвийн, 3.3 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, сая төг





Барилга угсралт их засварын ажлын 58.8 хувь нь инженерийн барилга, байгууламж, 26.8 хувь нь орон сууцны бус барилга, 10.7 хувь нь орон сууцны барилга, 3.6 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны бус барилгынх 10.3 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 5.9 пункт, их засварын ажлынх 2.7 пунктээр тус тус өсч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 18.9 пунктээр буурсан байна.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Сарын дундаж агаарын температур 1 дүгээр сард: Хатанбулаг суманд -9.1 градус, Мандах, Хөвсгөл сумдад -11.2...-11.7 градус, бусад сумдад -12.4...-18.0 градус, агаарын хамгийн их температур өдөртөө Сайхандулаан суманд 1 градус, Хөвсгөл суманд 4 градус, бусад сумдад -1...-6 градус байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Эрдэнэ суманд ОЖД-ийн орчим, бусад сумдад ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -23...-31 градус, өдөртөө Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад 10-11 градус, бусад сумдад -3...6 градус байв.

Хур тунадас: 1 дүгээр сард Хөвсгөл, Хатанбулаг, Сайхандулаан, Хатанбулаг сумдад цас ороогүй, бусад сумдын нутгаар 1...4 өдөр хур тунадастай байж, 0.0...0.2 мм цас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас бага цас орсон байна.

Салхи: Энэ сард Айраг, Алтанширээ, Иххэт, Өргөн сумдад салхины хамгийн их хурд секундэд 8-9 метр, бусад сумдын нутгаар 10-15 метр хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Айраг, Алтанширээ, Иххэт, Өргөнөөс бусад сумдад 1...12 өдөр байлаа.

Цасан бүрхүүлийн байдал: 1 дүгээр сарын 31-ний байдлаар Эрдэнэ, Айраг, Алтанширээ, Иххэт сумдад 10 баллын 2-8 см, Дэлгэрэх, Сайншанд, Өргөн, Хатанбулаг сумдад 1-4 баллын цасан бүрхүүлтэй, бусад сумдын нутгаар цасгүй байв.

_____ о О о _____

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**
(2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР)**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хvн	68.2	69.6	70.5	70.6	100.1
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	112	126	110	149	135.5
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	24	24	41	35	85.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	88	102	69	114	165.2
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	0	1	2	200.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.9	0.0	9.1	13.4	147.7
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 677	1 025	879	243	27.6
- Үүнээс эмэгтэй	тоо	732	517	417	114	27.3
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	395	237	203	52	25.7
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	12	2	1	0	0.0
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	12	1		0	0.0
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	0	1	0	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	95	41	85	121	142.4
- 10000 хүнд ногдох	тоо	14	6	12	17	142.1
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	76	43	65	55	84.6
- 10000 хүнд ногдох ***	тоо	18	10	15	12	84.6
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	5453.3	7989.1	13338.8	4474.4	33.5
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	10810.0	14531.1	24489.3	18553.0	75.8

* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I	2020 I	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	34.2	44.6	10.4	130.4
2. Ор хоног	мян.хүн	10.8	14.3	3.5	132.4
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	1.0	1.0	0	100.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	1.6	2.1	0.5	131.3
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	2.5	2.9	0.4	116.0
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.3	0.4	0.1	133.3
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	107	238	131	222.4
Үүнээс: нас баралт	хүн	5	5	0	100.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	183	203	20	110.9
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	163	189	26	116.0
8. Амаржсан эх	хүн	108	148	40	137.0
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	0	-1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	1	2	1	200.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 01 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	148	0	149	2	0
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг					
Хөвсгөл					
Эрдэнэ					
Сайншанд	118		119	2	
Замын - Үүд	30		30		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 01 сард

Үзүүлэлт	2019 I	2020 I	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	85	121	36	142.4
Вируст гепатит	2	0	-2	0.0
Сүрьеэ	0	6	6	0.0
Тэмбүү	16	12	-4	75.0
Заг хүйтэн	13	25	12	192.3
Трихоминиаз	24	13	-11	54.2
Цусан суулга	3	3	0	100.0
Бусад	27	62	35	3.2 ²

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 01 сард

Боловсролын түвшингээр	2017 I	2018 I	2019 I	2020 I	2020 I 2017 I	2020 I 2019 I
	хүний тоо				хувь	
ДҮН	1 677	1 025	879	243	14.5	27.6
Үүнээс: Эмэгтэй	877	517	417	114	13.0	27.3
Магистр, доктор	8	4	1	1	12.5	0.0
Дээд боловсролтой	406	230	128	50	12.3	39.1
Тусгай дунд	180	55	37	15	8.3	40.5
Техник мэргэжлийн	164	83	52	23	14.0	44.2
Бүрэн дунд	691	568	571	129	18.7	22.6
Бүрэн бус дунд	187	57	63	18	9.6	28.6
Бага	32	9	10	4	12.5	40.0
Боловсролгүй	9	19	17	3	33.3	17.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 01 САРД

Үзүүлэлт	2019 I	2020 I	2020 I 2019 I
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	2 519.8	2 814.0	111.7
Тэтгэврийн даатгалын сан	1 592.5	1 781.0	111.8
Тэтгэмжийн даатгалын сан	179.6	199.9	111.3
Эрүүл мэндийн даатгалын сан	419.7	469.1	111.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	258.7	287.3	111.1
Ажилгүйдлийн даатгалын сан	69.3	76.7	110.7
Нийгмийн даатгалын сангийн зарлага	3 959.5	4 327.8	109.3
Тэтгэврийн даатгалын сан	2 868.5	3 307.6	115.3
Тэтгэмжийн даатгалын сан	277.3	364.3	131.4
Эрүүл мэндийн даатгалын сан	560.8	389.2	69.4
ҮОМШӨ*-ний даатгалын сан	148.3	99.7	67.2
Ажилгүйдлийн даатгалын сан	104.6	167.0	159.7

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН 01 САРД

Үзүүлэлт	2019 I	2020 I	2020 I 2019 I
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	2818	3693	131.1
Албан журмаар даатгуулагчид	2311	3558	154.0
Аж ахуй нэгж, байгууллага	1102	1545	140.2
Төсөвт байгууллага	1209	2013	166.5
Сайн дураар даатгуулагчид	507	135	26.6
2. Тэтгэвэр авагчдын тоо	8434	8806	104.4
Өндөр насны тэтгэвэр	6078	6378	104.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1250	1292	103.4
Тэжээгчээ алдсаны	511	511	100.0
Цэргийн тэтгэвэр	438	470	107.3
ҮОМШӨ*-ний	157	155	98.7
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	3 008.4	3 405.8	113.2
Өндөр насны тэтгэвэр	2 126.3	2 470.6	116.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	327.1	375.0	114.6
Тэжээгчээ алдсаны	139.1	153.9	110.6
Цэргийн тэтгэвэр	267.6	306.6	114.6
ҮОМШӨ*-ний	148.3	99.7	67.2

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I	2020 I	2020 I 2019 I
	сая төгрөг		хувь
ДҮН	2519.8	2814.0	111.7
Айраг	49.5	59.2	119.5
Алтанширээ	12.9	26.1	201.7
Даланжаргалан	109.8	80.7	73.5
Дэлгэрэх	22.5	35.9	159.3
Иххэт	34.5	57.8	167.5
Мандах	24.0	35.5	147.9
Өргөн	144.1	77.6	53.9
Сайхандулаан	29.6	37.9	127.8
Улаанбадрах	24.3	25.1	103.5
Хатанбулаг	47.9	64.2	133.9
Хөвсгөл	24.1	28.6	118.8
Эрдэнэ	38.8	48.8	125.9
Сайншанд	1360.6	1445.1	106.2
Зүүнбаян баг	97.9	127.2	130.0
Замын-Үүд	499.2	664.3	133.1

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I	2020 I	2020 I 2019 I
	сая төгрөг		хувь
ДҮН	3959.5	4327.8	109.3
Айраг	190.6	219.4	115.1
Алтанширээ	72.2	81.5	112.9
Даланжаргалан	137.2	222.3	161.9
Дэлгэрэх	81.2	96.8	119.2
Иххэт	148.3	153.1	103.2
Мандах	77.2	100.5	130.2
Өргөн	153.6	157.5	102.5
Сайхандулаан	56.7	69.5	122.7
Улаанбадрах	80.5	94.9	118.0
Хатанбулаг	159.7	165.3	103.5
Хөвсгөл	68.3	79.0	115.7
Эрдэнэ	128.5	156.6	121.9
Сайншанд	1758.2	1752.8	99.7
Зүүнбаян баг	182.5	164.0	89.9
Замын-Үүд	664.9	814.7	122.5



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 01 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I 2019 I	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I 2019 I
	2019 I	2020 I		2019 I	2020 I	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	14457	7470	51.7	1245.3	523.1	42.0
1. Халамжийн тэтгэвэр	1249	1232	98.6	239.6	218.1	91.0
Ахмад настны тэтгэвэр	63	82	130.2	11.9	14.2	119.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1186	1150	97.0	227.7	203.9	89.5
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	853	817	95.8	66.4	70.0	105.4
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	804	776	96.5	61.9	66.5	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	41	38	92.7	3.5	3.3	94.3
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	3	50.0	0.8	0.2	25.0
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2		0.0	0.2		0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн						
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	164	225	137.2	26.3	45.3	172.2
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	164	212	129.3	26.3	35.7	135.7
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	0	6	0.0	0.0	0.4	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	0		0.0	0.0	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	0	1	0.0	0.0	2.0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I 2019 I	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I 2019 I
	2019 I	2020 I		2019 I	2020 I	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	0	0	0.0	0.0	0.0	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	0	5	0.0	0.0	6.0	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	0	0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	0	1	0.0	0.0	1.2	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	3748	2892	77.2	69.8	71.1	101.9
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	2038	117	5.7	25.5	17.2	67.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	113	22	19.5	4.2	5.6	133.3
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0		0.0	0.0		0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1217	2244	184.4	26.0	27.4	105.4
Банкны шимтгэл				0.0		0.0
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	380	509	133.9	14.1	20.9	148.2
6. Бусад халамжийн дүн	8443	2304	27.3	843.2	118.6	14.1
Алдарт эхийн одонгийн тусламж	3951		0.0	533.8		0.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	19	18	94.7	2.8	2.8	100.0
Цалинтай ээж хөтөлбөр	2293	2286	99.7	122.9	115.8	94.2
Насны хишгийн зардал	2180	0	0.0	183.7	0.0	0.0
Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал	0	0	0.0	0.0	0.0	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ

4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 01 сард

Хэргийн төрөл	2019 I	2020 I	зөрүү	Хэргийн бүтэц	
				2019 I	2020 I
				тоо	хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН	65	55	-10	100.0	100.0
Хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	3	-8	16.9	5.5
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1	1	0.0	1.8
Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг	20	10	-10	30.8	18.2
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	19	20	1	29.2	36.4
Хулгайлах	6	7	1	9.2	12.7
Залилах	3	2	-1	4.6	3.6
Гээгдэл эд зүйл ашиглах	1	2	1	1.5	3.6
үүнээс: Хөрөнгө завших	1		-1	1.5	0.0
Эд хөрөнгө устгах, гэмтээх	1		-1	1.5	0.0
Дээрэмдэх		2	2	0.0	3.6
Мал хулгайлах	7	7	0	10.8	12.7
Улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн	3	12	9	4.6	21.8
Авилгын гэмт хэрэг			0	0.0	0.0
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		1	1	0.0	1.8
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг	1		-1	1.5	0.0
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг			0	0.0	0.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	5	7	2	7.7	12.7
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	4	1	-3	6.2	1.8
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг			0	0.0	0.0
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг			0	0.0	0.0
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1		-1	1.5	0.0
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг			0	0.0	0.0
Бусад гэмт хэрэг	1		-1	1.5	0.0
согтуугаар үйлдсэн	12	4	-8	18.5	7.3
Гэмт гудамж, талбай	8	5	-3	12.3	9.1
гэр орон сууцанд	17	11	-6	26.2	20.0
бүлэглэн үйлдсэн	4	7	3	6.2	12.7
тоо хүүхэд оролцсон			0	0.0	0.0
эмэгтэй хүн оролцсон	5	3	-2	7.7	5.5
Гэмт 06.00 -14.00	15	20	5	23.1	36.4
хэрэг 14.00-19.00	22	16	-6	33.8	29.1
үйлдсэн 19.00 - 22.00	5	7	2	7.7	12.7
цаг 22.00 - 06.00	23	12	-11	35.4	21.8
Гэмт хэргийн нас барсан хүний тоо	11	3	-8		
улмаас гэмтэж бэртсэн хүний тоо	17	12	-5		

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар



4.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО , сумаар

	2019 I	2020 I	Үүнээс: хэргийн төрлөөр						Бусад
			Хүний амь	ХЭМХ учруулсан гэмт хэрэг	Хүчин	ХАБТХ АЖЗ*	Өмчийн хулгайн хэрэг		
							ИӨХ	Малын	
ДҮН	65	55	3	10	1	1	7	7	26
Айраг	2	6		1				2	3
Алтанширээ	1	2						2	
Даланжаргалан	8	4		1			1		2
Дэлгэрэх	1	5	1		1			1	2
Иххэт	5	3	1				1		1
Мандах	0	0							
Өргөн	1	2				1			1
Сайхандулаан	2	1						1	
Хатанбулаг	6	2							2
Улаанбадрах	1	1	1						
Хөвсгөл	2	0							
Эрдэнэ	3	1		1					
Сайншанд	20	10		3			3	1	3
Замын - Үүд	13	18		4			2		12

Тайлбар: *-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар



ТАВ. МӨНГӨ,ЗЭЭЛ

5.1 МӨНГӨН ГҮЙЛГЭЭ, ЗЭЭЛ, 2020 оны 01 сард

	Хэмжих нэгж	2019 I	2020 I	2020 I / 2019 I
		тоо		хувь
Нийт зээлийн үлдэгдэл	сая төгрөг	291957.0	288942.4	99.0
Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	сая төгрөг	2438.4	5186.7	2.2 ²
Чанаргүй зээлийн үлдэгдэл	сая төгрөг	6825.6	7877.0	115.4
Нийт харилцахын үлдэгдэл	сая төгрөг	32402.9	35704.4	110.2
Иргэдийн харилцахын үлдэгдэл	сая төгрөг	0.0	17089.1	0.0
Нийт хадгаламжийн үлдэгдэл	сая төгрөг	104248.3	118800.4	114.0
Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	сая төгрөг	0.0	113153.1	0.0
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	сая төгрөг	25966.7	29804.2	114.8
